



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Залуучуудын гудамж 01, Баянмөнх баг, Хэрлэн сум,
Чингис хот, Хэнтий аймаг, 23117
Утас/Факс: (976) 7056 2412,
Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn

2025.06.09 № 9/1308
танай _____-ны № _____-т

БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Х.ГАЛБАДРАХ ТАНАА

Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2025 оны 05 дугаар сарын 20-оос 2025 оны 05 дугаар сарын 24-ны хооронд сумдад ажиллаж бодлогын баримт бичгийн төлөвлөлт, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах үйл ажиллагаа хийсэн дүнг удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулан дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Дүгнэлт: Бодлогын баримт бичгийн төлөвлөлт

Сумын Засаг даргын 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 12 дугаар тогтоолоор сумын ИТХ-аар, сумын Засаг даргын 2025 оны А/41 дугаар захирамжаар Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан байна. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс сумдын Засаг даргын Тамгын газарт хамааралтай зорилт арга хэмжээг тусгасан боловч Ерөнхий боловсролын сургуультай холбоотой зарим арга хэмжээг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний суурь түвшин болон хүрэх түвшингээр төлөвлөсөн байна.

2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс 2025 онд хэрэгжих зорилт арга хэмжээг бүрэн тусгасан боловч “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийг орхигдуулсан. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнах тухай тусгаагүй.

Зарим төрийн жинхэнэ албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хүрээнд

231060357

зорилт, арга хэмжээ төлөвлөөгүй, төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэх гэрээний холбогдох заалт арга хэмжээг бүрэн тусгаагүй, шалгуур үзүүлэлтийг суурь түвшин болон хүрэх түвшинтэй уялдуулж оновчтой тодорхойлоогүй.

Эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний загвар буруу, Соёлын төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс үндсэн болон хамтран хэрэгжүүлэхээр заасан холбогдох заалт арга хэмжээг бүрэн тусгагдаагүй байна.

Зөвлөмж: Бодлогын баримт бичгийн төлөвлөлт

1.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан сумдад хамааралтай заалт арга хэмжээг бүрэн тусгах (суурь түвшин, хүрэх түвшингийн тоон үзүүлэлтийг сумын хэмжээнд тооцон төлөвлөх)

2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар, Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗГХЭГ-ын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар буюу батлагдсан загварын дагуу тус тус төлөвлөх (сумын Эрүүл мэндийн төв анхаарах)

3.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2025 оны хэрэгжүүлэх заалт арга хэмжээг бүрэн тусгах

4.Аймгийн Засаг даргын 2022 оны А/289 захирамжийн хавсралтын дагуу тайлангуудыг заасан хугацаанд тайлагнах, тайланг хэн хариуцах талаар байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд эзэнжүүлэн тусгах

5.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн холбогдох заалт, арга хэмжээний жагсаалт гарган эзэнжүүлж, байгууллагын даргаар баталгаажуулан, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнах тухай байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах

6.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд уялдуулан өөрт хамааралтай арга хэмжээ болгоныг төрийн жинхэнэ албан хаагч гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө зорилт болгож аваад нарийвчлан задалж боловсруулах /албан тушаалын тодорхойлолтод заасан зорилт, чиг үүргийг тусгах/

3.

7.Бодлогын баримт бичгийг төлөвлөхдөө тавигдах шаардлагын дагуу шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг нарийвчилсан байдлаар оновчтой тодорхойлох

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс хийсэн хяналт, шалгалт

1.Бүтэц, орон тооны шийдвэрийг жил бүр батлахгүй байх. Сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг Засгийн газрын тогтоолын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан орон тооны хязгаарт багтааж ажиллуулах ба чиг үүрэг бүтэц, хүн амын тоо өөрчлөгдсөн тохиолдолд Засгийн газрын шийдвэр, аймгийн Засаг даргын захирамжийг үндэслэж орон тооны хязгаарт багтааж бүтэц, орон тоо баталсан шийдвэрийг дахин өөрчилнө.

2.Албан хаагчдыг цаашид тогтвор суурьшилтай ажиллуулахад сэдэлжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах

3.Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу албан хаагчдын хувийн хэргийн бүрдүүлэлтийг хангах, албан тушаалын картыг зөв, хөтлөх

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

А.ЖАРГАЛСАЙХАН

